4.2 Дэвшилтийн бүртгэл хийх

4.2 Дэвшилтийн бүртгэл хийх

Суралцагчийг дэвшилтийн бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасах алхамчилсан дараалал дараах байдалтай байна.

Үйл ажиллагааны жагсаалтаас **Дэвшилт**-ийг сонгоход дараах цонх нээгдэнэ.



Дэвшилтийн бүртгэл хийхэд дараах бүртгэлийг хийнэ.

Алхам	Үйл явц	Тайлбар
1.	Сургалтын хөтөлбөр сонгох	• Бага боловсролын хөтөлбөр • Суурь боловсролын хөтөлбөр • Бүрэн дунд боловсролын хөтөлбөр
2.	Анги сонгох	Дэвшилтийн бүртгэл нь зөвхөн дараах анги харагдана. • Бага боловсрол – I, II, III, IV • Суурь боловсрол – VI, VII, VIII • Бүрэн дунд боловсрол – X, XI
3.	Бүлэг сонгох	Ангиийг бүртгэсэн бол бүлгийн сонголт хийнэ.
4.	Дэвшилтийн хянах самбар	Дээрх сонгогдсон бүлгийн хувьд харагдах хянах самбар юм. Уг самбар дах бүртгэл нь дараах утгыг агуулна. • **Нийт** – Сонгогдсон бүлгийн хувьд батлагдсан, идэвхтэй суралцагчийн тоог харуулсан. • **Дэвшсэн** – Дэвшсэн суралцагчийн тоог • **Давтан** – Суралцагчдаас давтан суралцах суралцагчидын тоог • **Бүртгүүлсэн** – Суралцагчийн бүртгэл хийгээд зөвхөн хадгаласан бүртгэлийн тоог • **Бүртгээгүй** – Суралцагчдаас бүртгэл хийгээгүй шийдвэр хийж хадгалаагүй суралцагчдын тоог • **Хянагдаж байгаа** – Дэвшилтийн бүртгэл сургалтын менежерт хянагдаж байгаа сурлцагчдын тоог • **Цуцалсан** – Дэвшсэн бүртгэлээс цуцалсан суралцагчдын тоог харуулж байгаа.
5.	Дэвшилтийн бүртгэл	Уг **дэвшилтийн бүртгэл** хийх товчоор дараах бүртгэлийг хийж байж

Анхаарах зүйлс: Сургалтын хөтөлбөр, анги, бүлэг сонголтыг сайтар хянаж байж дэвшилтийн бүртгэлийг хийнэ үү.




АНГИ ДЭВШИЛТИЙН БҮРТГЭЛ
2017 - 2018 хичээлийн жил
Дэвших анги: 8-а (1-р ээлж)
Дэвшигч бүртгэх
Хадгалах
1
10
4
36 Нийт
0 Дэвшсэн
0 Давтан
2 Бүртгүүлсэн
34 Бүртгээгүй
0 Хянадаж байгаа
0 Цуцалсан
№
Сурагчагч
Регистр
Шийдвэр
5
Шалтгаан
6
Дэвших анги
Шийдвэрийн №
7
Огноо
8
Төлөв
9
1
2
3
4
Дэвшүүлэх
Сурагчах түвшин амжилттай
9-р анги
А/36
2018-05-22
Бүртгүүлсэн
Бүртгээгүй

Алхам	Үйл явц	Тайлбар
4.	Суралцагч	Дэвшилтийн бүртгэл хийх суралцагчийг сонгох
5.	Шийдвэр	Уг шийдвэр • Дэвшүүлэх – 8-р ангийн суралцагч 9-р ангид дэвшин суралцах төлвийг илэрхийлнэ. • Давтан суралцуулах- 8-р ангийн суралцагч 8-р ангид ахин суралцах төлвийг илэрхийлнэ.
6.	Шалтгаан	Дээрх шийдвэрээс хамаарч шалтгааныг сонгож оруулах боломжтой. • Дэвшүүлэх – Бусад, Суралцах түвшин амжилттай • Давтан суралцуулах – дараах сонголтоос хийх боломжтой. Эрүүл мэндийн шалтгаанаар Сурлагын амжилт хангалтгүй Хичээл дутуу судалсан Шалгалт өгөөгүй(Төгсөх эсвэл дэвших) Ирэхээ больсон Гэмт хэрэгт холбогдсон Амьдралын шаардлагаар
7.	Шийдвэрийн №	Уг дэвшүүлэх болон давтан суралцах шийдвэр гарсан бол шийдвэрийн дугаарыг оруулна уу.
8.	Огноо	Дэвшилтийн бүртгэл хийсэн огноог оруулж өгнө үү.
9.	Төлөв	• Бүртгээгүй – Дэвшилтийн бүртгэл хийх үйлдэл хийгдээгүй суралцагчийн дээрх төлөвтэй байна. • Бүртгүүлсэн – Дэвшилтийн бүртгэл хийгээд хадгалсан бол уг төлөвт шилжинэ • Дэвшсэн – Суралцагчийн дэвшилт хийх бүртгэлийг Сургалтын менежер баталгаажуулсан бол дээрх төлөвт шилжинэ. • Давтан – Суралцагчийг давтан суралцуулахаар шийдвэр гарсан төлөв.
10.	Хадгалах	Нийт суралцагчдын дэвшилт, давтан суралцуулах шийдвэр гарч бүртгэлийг хийсэн бол Хадгалах товч дарсан үед сургалтын менежер баталгаажуулах боломжтой болно.